НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 30 өдөр Дугаар А/205 Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн газрын данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/645 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Техникийн комиссын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдахаар шийдвэрлэгдсэн нийт 14,499,900.00 (арван дөрвөн сая дөрвөн зуун ерэн есөн мянга есөн зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 5 тээврийн хэрэгслийг хавсралтын дагуу данс бүртгэлээсээ хасахыг Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн газар (Х.Ууганбаяр)-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлтийг хийж, тээврийн хэрэгслийн гэрчилгээ улсын дугаарыг хураан авч авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн газар (Х.Ууганбаяр)-т, татан төвлөрүүлж, хөрөнгийг 90,000.00 (ерэн мянга) төгрөгөөр худалдан борлуулж, төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус даалгасугай.

3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА В.ОЮУМАА

1425019599

Prilad \B. Tushaal. docx

Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж нэг хувийг Захиалагч эзэмшиж, нэг хувийг Гүйцэтгэгч эзэмшинэ.

Захиалагч: Д. Энхжаргал

Гүйцэтгэгч: Б. Оюунаа

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2025 оны 06 дугаар сарын 10-ны
өдрийн А/105 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах тээврийн хэрэгслийн жагсаалт

№	Автомашины марк	Арлын дугаар	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Худалдан борлуулах доод үнэ
1	Хятад Super beny Хар	LV4800KCB10K029304	3,000,000.0	3,000,000.0	-	18,000.00
2	Япон Honda хар	ME4JC589KET311545	2,499,900.0	2,499,900.0	-	18,000.00
3	Хятад Fekon-FK Хар	LDAPAJ106G700926	3,000,000.0	3,000,000.0	-	18,000.00
4	Хятад Fekon-FK Хар	LDAPAJ10XG700929	3,000,000.0	3,000,000.0	-	18,000.00
5	Хятад Fekon-FK Хар	LDAPAJ108JG780930	3,000,000.0	3,000,000.0	-	18,000.00
Нийт дүн			**14,499,900.00**	**14,499,900.00**	**-**	**90,000.00**